

МОНГОЛ УЛСАД РАДИО ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙГ ТООН ТЕХНОЛОГИД
ШИЛЖҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү баримт бичиг нь Монгол Улсад радио өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэхэд баримтлах чиглэлийг тодорхойлно.

ХОЁР. АШИГЛАХ ДАВТАМЖИЙН ЗУРВАС

2.1 Тоон радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах сүлжээ нь Монгол Улсын төрийн өмч байна.

2.2 Монгол Улсад радио өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэхэд Олон улсын цахилгаан холбооны байгууллагын (ITU) давтамж төлөвлөлтийн дагуу хуваарилсан давтамж, зурвасыг ашиглана. Үүнд:

Долгионы төрөл	ОУЦХБ-аас хуваарилсан хуваарилалт	Үндэсний давтамжийн хуваарилалт	Давтамжийн зурвас /өргөн/
Урт долгион	148.5-255кГц	164кГц 209 кГц 227 кГц	9 кГц
Дунд долгион	526.5-1606.5 кГц	882 кГц, 990 кГц	8 кГц
Богино долгион	3950 - 26100 кГц	3950 - 26100 кГц	10 кГц

2.3 Шаардлагатай тохиолдолд дараах нөөц давтамжийг ашиглаж болно.

Урт долгион	Дунд долгион	Богино долгион
148.5-283.5кГц	526:5- 1606.5 кГц	2.3 -26.1 кГц

2.4 Дэлхийн радио холбооны их хурал (WRC)-аас гаргасан шийдвэрүүдийг үндэслэн дээрхи давтамжийн зурваст өөрчлөлт оруулж болно.

ГУРАВ. СТАНДАРТ

3.1. Монгол Улсын нутаг дэвсгэрийг бүрэн хамарсан тоон радиогийн сүлжээ байгуулахад Европын холбооны ETSI ES 201 980 (Тоон радиогийн систем) стандарт буюу DRM (Digital radio mondiale), DRM+ (Digital radio mondiale +) стандартыг ашиглана.

ДӨРӨВ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ, НЭВТРҮҮЛЭХ ҮЕ ШАТУУД

4.1 Монгол Улсад радио өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх арга хэмжээг тодорхой үе шаттайгаар нэгдсэн төлөвлөлтийн дагуу удирдан зохион байгуулж хэрэгжүүлнэ.

4.2 Радио өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын хүрээнд улсын хэмжээнд нэвтрүүлэг дамжуулах их чадлын станцуудыг барьж байгуулах хөрөнгийн эх үүсвэрийг гадаадын урт хугацааны хөнгөлттэй зээл, тусламж эсвэл төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх чиглэл барина.

4.3 Монгол Улсын нутаг дэвсгэрийг бүрэн хамарсан тоон радио өргөн нэвтрүүлгийн сүлжээг байгуулах үе шатыг хэрэгжүүлэхдээ эхний ээлжинд хөрөнгө оруулалт их шаардсан тоон дамжуулах станцуудыг байгуулж, дараагийн үе шатуудад нэвтрүүлэг бэлтгэгч, хэрэглэгчийн тоног төхөөрөмжийг зах зээлийн зарчмаар нь тодорхой хугацаатайгаар тоон технологид шилжүүлэх чиглэл баримтална.

4.4 Хэрэглэгчдийг тоон радиогоор хангах асуудлыг тоон радио бүхий автомашин, иргэний зориулалттай хямд найдвартай хүлээн авагчийг импортоор оруулж ирж худалдаалах зарчим бүхий шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагуудаар гаргуулж хэрэгжүүлэх зарчмыг баримтлан ажиллана.

ТАВ. ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДЭД ТАВИГДАХ НӨХЦӨЛ ШААРДЛАГА

5.1 Монгол Улсын нутаг дэвсгэрийг бүрэн хамарсан тоон радиогийн сүлжээгээр нэвтрүүлгээ дамжуулах, контентын үйлчилгээ эрхлэх Үндэсний олон нийтийн радиогоос бусад аж ахуй нэгж, иргэнийг сонгон шалгаруулалтын зарчмаар шийдвэрлэх ба үйлчилгээ эрхлэгч нь онцгой байдал, гамшгийн үеийн зарлан мэдээллэх, цаг үеийн шинжтэй мэдээлэл, орон нутгийн нэвтрүүлэг зэргийг дамжуулах боломжийг бүрдүүлсэн байна.

5.2 Монгол Улсын нутаг дэвсгэрийг хамарсан тоон радиогийн сүлжээнээс гадна хэд хэдэн аймаг сумыг хамарсан сүлжээ байгуулж, ашиглах хүсэлт гаргасан аж ахуйн нэгж, байгууллага нь тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангасан тохиолдолд дэд сүлжээ байгуулан ажиллаж болно.

Зургаа. Бусад

Энэхүү баримтлах чиглэлийг техник, технологийн хөгжил дэвшлийн дагуу тухай бүр өөрчилж болно.

МЭДЭЭЛЭЛ, ШУУДАН, ХАРИЛЦАА ХОЛБОО, ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2011 оны ...дугаар сарын

Дугаар 4

Улаанбаатар хот

...ний өдөр

Монгол Улсын Засгийн Газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэхь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, Монгол Улсын засгийн газрын Үндэсний хөтөлбөр батлах тухай 275 дугаар тогтоолын 5.1 дэх заалт, Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын даргын зөвлөлийн хурлын 2011 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн 4 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Монгол Улсад радио өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэхэд баримтлах чиглэл”-ийг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Дээрх баримтлах чиглэлийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Б.Амгаланбат /-д үүрэг болгосугай.

Гарын үсэг